



“Эмнэлгийн Инженерчлэлийн Ирээдүй” Эрдэм шинжилгээний хурлын удирдамж

Зорилго: Эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа болон шинээр нэвтэрч буй сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдийн хэрэглээ, ашиглалтын мэдээллийг түгээх, тухайн мэргэжлээр суралцаж буй дэд бакалавр, бакалавр, магистрант, докторант оюутнуудын судалгааны ажил, бүтээлийг танилцуулах, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой. “Эмнэлгийн инженерчлэлийн ирээдүй” эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улсын их, дээд сургуулиудад Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч мэргэжлээр суралцаж буй нийт оюутан, судлаач нарын дунд зарлаж байна.

Зохион байгуулагч: ШУТИС- ЭХИС-Цахилгаан техникийн салбар
Сүвэн Уул ХХК
“Залуу Инженер” клуб

Сэдэв: “Эрүүл мэндийн салбар дахь техник, технологи”

Хамрах хүрээ: Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч мэргэжлээр суралцаж буй оюутан, судлаач нар оролцно.

Оюутан нь бие даан болон багаар оролцох боломжтой. Багаар оролцож буй тохиолдолд 1 баг 2-3 гишүүнтэй байна. Оролцогч удирдагчтай байж болох ба материалдаа дурдсан байна. (Үндсэн шүүгчдийн бүрэлдэхүүнд орсон бол удирдагчаар ажиллахгүй).

- Биет бүтээлийн үзэсгэлэнг гаргаж, шалгаруулна.
- Эрдэм шинжилгээний өгүүллийг 2 үе шаттай шалгаруулна.

Эрдэм шинжилгээний өгүүллийн I шат (2025.04.09 - 2025.04.29)

Оролцогч нь “Эрүүл мэндийн салбар дахь техник, технологи” сэдвийн хүрээнд судалж буй сэдвээрээ эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл зэргийг шаардлагын дагуу бэлтгэн өөрийн танилцуулгын хамт цахимаар ирүүлнэ.

Судалгаанд тавигдах шаардлага:

- Урьд нь хэвлэгдэж нийтлэгдээгүй бүтээл байх
- Эрдэм шинжилгээний хуралд ирүүлэх илтгэл, өгүүлэлд эрдэм шинжилгээний судалгаа, практик болон туршилтын үр дүнг тусгасан байна. Өгүүлэл нь дараах дэс дараалалтай байна. Үүнд:
 - I. Хураангуй
 - II. Оршил (Судалгааны ажлын ач холбогдол тухайн сэдэв ямар түвшинд онцлог чухал болохыг дурдах мөн судлагдсан байдал, зорилго, өгүүллийн бүтцийг багтаасан байна)
 - III. Судалгааны арга аргачлал (судалгааны ажил гүйцэтгэсэн туршилтын объект, материалын тухай мэдээлэл)
 - IV. Судалгааны ажлын үр дүн (үр дүнг судалгааны шинжилгээ боловсруулах аргаар боловсруулсан байна)
 - V. Судалгааны ажлын хэлэлцүүлэг (сэдвийн гадаад, дотоодод судлагдсан байдал)
 - VI. Дүгнэлт (судалгааны ажлын ерөнхий дүгнэлт)
 - VII. Эшлэл (ашигласан материалын дарааллаар зүйлчлэл хийнэ)

• Судалгааг **word** программ дээр
https://www.must.edu.mn/media/uploads/2021/09/20/must_paper-format_sep2021.docx –
аар бэлтгэнэ.

Эрдэм шинжилгээний өгүүллийн II шат (2025.05.03)

Шалгарсан оролцогчид зохион байгуулагчдаас заасан шаардлагын дагуу материалаа сайжруулан 15 минутанд багтаан илтгэнэ.

Илтгэлд тавигдах шаардлага:

1. Илтгэлийг MS office **power point** программ дээр, 25-аас ихгүй хуудсанд багтаан бэлтгэнэ.
2. Ишлэл татсан ном, зохиолын нэрс, вэб хуудас зэргийн жагсаалт болон мэдээлэл авсан эх сурвалжийг илтгэлийн сүүлийн хуудсанд оруулна.
3. Нийтээр хэрэглэж заншаагүй нэр томъёо болон товчилсон үгсийн томъёог тайлбараар оруулна.
4. Илтгэлд орсон зураг, дүрс бичлэгүүд нь чанарын өндөр түвшинд байна.
5. Бүтээлийг дүрсжүүлэн, хөдөлгөөнт видео контент хэлбэрээр хүмүүст ойлгогдохуйц хэлбэрээр хийж болно.
6. Нэмэлт үзүүлэн материалууд ашиглах боломжтой.
 - Илтгэл танилцуулах хугацаа: 15 минут.
 - Шүүгчид оролцогчдоос илтгэл тавьсны дараа нэмэлт асуулт асууж болно.

Бүтээлд тавигдах шаардлага:

1. Бүтээл нь электроникийн асуудлыг шийдсэн, биеэ даасан үйл ажиллагаатай байна.
2. Шинэлэг байдал: Зохион бүтээх ажлын сэдэв нь шинэ санаа, шинэ технологи эсвэл одоо байгаа бүтээгдэхүүн, процессийг сайжруулахад чиглэсэн байх.
3. Практик ач холбогдол: Сэдэв нь бодит амьдралд хэрэгжих боломжтой, тодорхой салбарт хэрэгцээтэй, ашиг тустай байх.
4. Техникийн түвшин: Сэдэв нь оюутны техникийн мэдлэг, чадварт тохирсон, бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой байх.
5. Бүтээлийн гарын авлагыг боловсруулсан байна.

Бүтээлийн гарын авлаганы агуулга:

1. Практик ач холбогдол (хөрвөх чадвартай байх)
2. Физик үндэс (онолын үндэслэл, зураг, томъёо гэх мэтийг оновчтой зохих дараалалтай оруулах)
3. Цахилгаан ба блок схемийг зохих стандартын дагуу зурж тайлбарласан байх
4. Тооцооны хэсэгтэй байх
5. Эдийн засгийн харьцуулсан тооцоо хийх (элементийн жагсаалт гаргах, тухайн бүтээл хэдэг төгрөгөөр бүтсэн ба түүнтэй ижил техник үзүүлэлттэй бүтээлийн зах зээлийн үнэтэй харьцуулалт хийх)
6. Цаашид хөгжүүлэх боломжтой байх
7. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулсан байх (ямар зориулалттай хэрхэн яаж ашиглах талаар фото зураг үзүүлэн ашиглан нэг бүрчлэн тайлбарласан байх)
8. Програмын алгоритм зурж тайлбарлах
9. Программ хангамжийг хавсаргах
10. Биет бүтээлийн дүгнэлт

Жич: Агуулгын хүрээнд А5 хэмжээгээр бэлтгэх.

Бүтээлийн шалгаруулалт: Бүтээлээр оролцогчид 2025 оны 05 дүгээр сарын 03-ны өдөр 09:00 цагт үзэсгэлэнд бүтээлээ бүртгүүлж, танилцуулна.

Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2025.04.29

Материал хүлээн авах цахим хаяг: boka.bumbat@must.edu.mn

Хариу мэдэгдэх хугацаа: 2025.05.01. ЭШӨ-ээ илгээсэн и-мэйл хаягаар мэдээллэнэ.

“Эрдэм шинжилгээний өгүүлэл” болон “Биет бүтээл”-ийг 2025 оны 05 дүгээр сарын 03-ны өдөр 09:00 цагт ШУТИС, VIII байрны 12-р давхрын Олон улсын эрдэм шинжилгээний хурлын танхимд Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн бүрэлдэхүүнтэй комисс шалгаруулж, шагналыг гардуулна.

Зохион байгуулах комисстой холбоо барих:

Утас: 88969790, 99180396, 88094285

И-мэйл: **boka.bumbat@must.edu.mn**

ОРОЛЦОГЧДОД АМЖИЛТ ХҮСЬЕ!